



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/1467

Улаанбаатар хот

### Захирамжийн хавсралтыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 218 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 11/34 дүгээр, 2022 оны 65 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” Нийслэлийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн А/1149 дүгээр захирамжийн 1, 2 дугаар хавсралтаар батлагдсан жагсаалтыг хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2.Энэ захирамжийн хавсралтуудад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай 325.6 (гурван зуун хорин таван сая зургаан зуун мянга) сая төгрөгийг “Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний шинэчилсэн жагсаалт”-ын “Авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын “29”-т заасан “Цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээ”-ний хөрөнгөөс гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Мишээлт)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Д.СУМЬЯАБАЗАР



111020006736

Нийслэлийн Засаг даргын 2022 оны  
11 дугаар сарын 18-ны өдрийн  
захирамжийн  
1 дүгээр хавсралт



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН  
БАЙГУУЛЛАГАД ИЖ БҮРЭН ГЭР ЦЭЦЭРЛЭГ  
ХУДАЛДАН АВАХ ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Иж бүрэн гэр цэцэрлэг (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 158 дугаар цэцэрлэг)	2022	2022	84.4	84.4
2	Иж бүрэн гэр цэцэрлэг (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 188 дугаар цэцэрлэг)	2022	2022	96.5	96.5
3	Иж бүрэн гэр цэцэрлэг (Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 271 дүгээр цэцэрлэг)	2022	2022	24.1	24.1
ДҮН				205.0	205.0

Нийслэлийн Засаг даргын 2022 оны  
11 дугаар сарын 18-ны өдрийн  
11/19/22 дугаар захирамжийн  
2 дугаар хавсралт

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН  
БАЙГУУЛЛАГАД ИЖ БҮРЭН ГЭР ЦЭЦЭРЛЭГ  
ХУДАЛДАН АВАХ ЖАГСААЛТ

(сая төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Иж бүрэн гэр цэцэрлэг (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 257 дугаар цэцэрлэг)	2022	2022	36.2	36.2
2	Иж бүрэн гэр цэцэрлэг (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 20 дугаар цэцэрлэг)	2022	2022	48.2	48.2
3	Иж бүрэн гэр цэцэрлэг (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 302 дугаар цэцэрлэг)	2022	2022	36.2	36.2
ДҮН				120.6	120.6